



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилон
ажиллуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 98 дугаар зүйлийн 98.1, 109 дүгээр зүйлийн 109.4 дэх заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 7.25 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.1 дэх заалт, заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цагаан сар, билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3-ны өдрүүдэд бүх нийтээр амрахтай холбогдуулан нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, эрүүл ахуйн дэглэм, ажлын байрны дэг журам, сахилга батыг чанд сахиулах, ажлын зохион байгуулалтыг сайжруулж, бэлэн байдлыг хангах зорилгоор 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 20.00 цагаас 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 08.00 цаг хүртэл ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Харьяа алба, салбар нэгжүүд бүх нийтээр амрах амралтын өдрүүдэд хариуцлагатай жижүүр томилон, Иргэний нисэхийн үндэсний төвийн хариуцлагатай жижүүрт удирдамжийн дагуу мэдээ, мэдээлэл тогтмол өгч, нисэхийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа, бэлэн байдлыг ханган ажиллахыг алба, салбар нэгжийн дарга нарт, хариуцлагатай жижүүрийг автомашинаар хангахыг Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба (Б.Гантулга)-нд тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, батлагдсан хуваарийн дагуу ажилласан хариуцлагатай жижүүрийг нөхөн амраахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН

1723 01 0170


Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн
17.18 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

Д/д	Нэр	Албан тушаал	Хугацаа	Утас
1.	Ж.Батбаяр	Гэрэл суулт, цахилгаан хангалтын албаны дарга	II/20-ны 20.00 II/21-ний 08.00	7128-3094 99082405
2.	Б.Сэр-Од	Аюулгүй байдал, хамгаалалтын албаны дарга	II/21-ний 08.00 II/21-ний 20.00	7128-3004 99111683
3.	Б.Бадрал	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны дэд дарга	II/21-ний 20.00 II/22-ны 08.00	7128-1771 99096041
4.	Р.Амарбаясгалан	Хамтын ажиллагааны газрын менежер	II/22-ны 08.00 II/22-ны 20.00	88102929
5.	Г.Цэвээнгэрэл	Мэдээллийн аюулгүй байдал, технологийн албаны дарга	II/22-ны 20.00 II/23-ны 08.00	7128-3013 88118152
6.	Н.Идэр	Агаарын навигацийн үйлчилгээний газрын менежер	II/23-ны 08.00 II/23-ны 20.00	7128-3089 99005354
7.	Б.Гантулга	Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны ерөнхий инженер	II/23-ны 20.00 II/24-ний 08.00	7128-4057 99022789

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн
А/118 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН АЖЛЫН УДИРДАМЖ

Хариуцлагатай жижүүр нь Иргэний нисэхийн үндэсний төв, түүний харьяа алба, салбар нэгжүүдийн уялдаа холбоо, нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх үйлдвэрлэлийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагаа, нислэг үйлдвэрлэлийн бэлэн байдал, аюулгүй ажиллагаа, ажлын зохион байгуулалтыг хэрэгжүүлэн дараах удирдамжийн дагуу ажиллана.

1. Нислэгийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл шаардлага, ажлын байрны дэг журам, сахилга бат алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор харьяа нэгжийн ажлын байраар явж, үзлэг шалгалт хийж, үйлдвэрлэлийн хэвийн найдвартай ажиллагаанд байнга хяналт тавьж ажиллана.

2. Харьяа алба, салбар нэгжийн тоног төхөөрөмж, технологийн болон хүн тээврийн, автомашинуудын техникийн бэлэн байдал, найдвартай ажиллагааг хангах, засвар үйлчилгээ, өдөр тутмын үзлэг шалгалт, хяналтыг сайжруулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд саатал, доголдол гаргахгүй байх талаар хийгдэж буй ажлуудад үзлэг шалгалт хийнэ.

3. Объектуудын цахилгаан болон галын аюулгүй байдал хангагдсан эсэх, хөдөлмөр хамгааллын зааварчилгаа, эрүүл ахуйн нөхцөл хангаж байгаа эсэхийг шалгаж ажиллана.

4. Харьяа алба, салбар нэгжүүдийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавина.

5. Харьяа алба, салбар нэгжүүдээс ирүүлсэн зөрчил, дутагдал гарч болзошгүй аливаа нөхцөл байдал бий болсон талаар харьяа нэгжийн удирдлага, ажилтнуудаас гарсан санал, мэдээллийг хүлээн авч, холбогдох удирдлагад мэдэгдэж, урьдчилан сэргийлж ажиллана.

6. Харьяа алба, салбар нэгжүүдээс ирүүлсэн мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийж шаардлагатай мэдээллийг ИНЕГ-аас томилогдсон ерөнхий эргүүлд мэдэгдэнэ.

7. Хариуцлагатай жижүүр нь өөрсдийн ажлын байрандаа байрлаж ажиллана. Ажиллах хугацаандаа гар утсаа байнга нээлттэй байлгаж харьяа алба, салбар нэгжүүдээс томилогдсон хариуцлагатай жижүүрүүдээс мэдээллийг 2 цаг тутамд авч хариуцлагатай жижүүрийн дэвтэрт дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөн, шаардлагатай дүн мэдээ, баримтыг хавсаргах бөгөөд хариуцлагатай жижүүрийн дэвтэр, үнэмлэхийг дараагийн жижүүрт хүлээлгэн өгнө.

8. Томилогдсон хариуцлагатай жижүүр нь нөхөн амралтыг тухайн жижүүрт гарсан өдрөөс хойш ажлын 30 хоногт багтаан амралтыг эдэлнэ.

ЯАРАЛТАЙ ҮЕД ХОЛБОГДОХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН
УТАСНЫ ЖАГСААЛТ

Д/д	Албан тушаал	Нэрс	Утасны дугаар
1.	ИНЕГ-ын дарга	Ч.Мөнхтуяа	99113244
2.	ИНЕГ-ын НААХЗА-ны дарга	П.Ганболд	89109270
3.	ИНЕГ-ын Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газрын дарга	Ч.Одгэрэл	99059805
4.	Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга	Н.Батсайхан	88089002
5.	Нисэх буудлуудын үйлчилгээний газрын дарга	С.Нацагдорж	99117682
6.	Агаарын навигацийн үйлчилгээний газрын дарга	Э.Төрбаяр	99081744
7.	НААХЗА-ны шуурхай мэдээллийн утас	жижүүр	98985525
8.	"Чингис хаан" ОУНБ-ын ээлжийн менежер	-	7128-7300
9.	"Буянт-Ухаа" ОУНБ-ын нислэг үйлдвэрлэлийн зохицуулагч	-	7128-3047
10.	УБ цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн баруун түгээх төв	диспетчер	7004-7004
11.	Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэс	жижүүр	283061, 99328102
12.	Нийслэлийн онцгой байдлын газрын харьяа, Мэдээлэл шуурхай удирдлагын төв	мэдээлэл хүлээн авагч	7019-1104
13.	Ус сувгийн удирдах газар	жижүүр	7015-7016,7015-7066